



НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/89

Улаанбаатар хот

Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 800,000,000 (найман зуун сая) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Нийслэлийн орон сууцны корпораци ХК-д шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Орон сууцны бодлогын газар (Г.Ганхүү)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Нийслэлийн орон сууцны корпораци ХК (М.Говьсайхан)-д даалгасугай.

3.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Орон сууцны бодлогын газар (Г.Ганхүү), Нийслэлийн орон сууцны корпораци ХК (М.Говьсайхан)-д тус тус үүрэг болгосугай.4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.


ДАРГА



М.БАЯРАА

115050000251

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
даргын 2022 оны 23 дугаар сарын 11 ний  
9/89 дугаар тушаалын хавсралт



Балансаас балансд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага : Нийслэлийн Орон сууцны бодлогын газар

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
Тоног төхөөрөмж									
1	Цахилгаан шат	2016	ш	4	120,000,000	480,000,000	131,000,000.00	349,000,000.0	Нийслэлийн орон сууцны корпораци ХК
2	Цахилгаан шат	2019	ш	4	80,000,000	320,000,000	61,333,333.41	258,666,666.6	
<b>Тоног төхөөрөмжийн дүн</b>						<b>800,000,000</b>	<b>192,333,333.41</b>	<b>349,000,000.0</b>	
<b>Нийт хөрөнгийн дүн</b>						<b>800,000,000</b>	<b>192,333,333.41</b>	<b>349,000,000.00</b>	